



ТӨВ АЙМГИЙН
БАЯНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 14

Баяндэлгэр уул

Сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн
тайлан, орон нутгийн өмчийн дүнд
дүгнэлт гаргах тухай

Сумын 2021 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Аудитын дүгнэлт, орон нутгийн өмчийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 35.1.11, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, 64.1.3, 64.1.4 "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус наймдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Төсөвт байгууллагууд болон сумын нэгдсэн санхүүгийн тайлан, Орон нутгийн өмчийн 2021 оны дүнг хугацаанд нь тушаан аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэгдсэнийг сайшаан тэмдэглэсүгэй
2. Төсвийн хууль, Орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу өмч хөрөнгөнд хяналт тавьж ажиллахыг Байгууллагын дарга эрхлэгч ,нягтлан бодогч нарт үүрэг болгон тогтмол хяналт удирдлагаар хангах, жилийн тайлан мэдээний гүйцэтгэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (З.Дэлгэрцэцэг)-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хороо (Д.Пионер)-нд хороонд даалгасугай.

ДАРГА

Ц.ЭНХТҮВШИН

